



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 09

Мөрөн

**Аймгийн 2020 оны газар зохион байгуулалтын
төлөвлөгөө батлах тухай**

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.2.3 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/, Мөрөн сумын Засаг дарга /Ц.Гансүх/, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Ганзориг/ нарт үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга / Ц.Гончиг /-д даалгасугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

011912039

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит
XI хуралдааны 09 дугаар тогтоолын хавсралт

ҮНДЭСЛЭЛ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Газар зохион байгуулалт хийх журам", Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газрын даргын 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 497 тоот тушаалаар баталсан "Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 2 сарын 13-ны өдрийн 05 дугаар д баталсан Хөвсгөл аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тус тус үндэслэн боловсрууллаа.

Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй бүсийн 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлэхээр тусгаж байна. Үүнд:



1. Барилга байгууламжийн дэвсгэр газрын төлөвлөлт
2. Баг хорооны хил, заагийг баталгаажуулах ажлыг дуусгах
3. Геодезийн байнгын цэг тэмдэгтийг тоолж дуусгах /50 өргөрөгөөс хойших сумд / Үлдсэн 13 сум
4. Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажлыг 10 суманд хэрэгжүүлэх


Барилга байгууламжийн дэвсгэр газрын төлөвлөлт

1. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт

№	Байршил	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	7-р баг	5	0.4	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ
2	7-р баг	1	0.07	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ

3	1-р баг Ирээдүй сургуулийн урд	10	0.75	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ
4	1-р баг Гандангийн баруун хойд буланд	1	0.0531	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ
5	13-р баг 4-р цэцэрлэгийн урд	1	0.0485	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ
6	8-р баг	3	0.12	Гэр бүлийн хэрэгцээ	2-р улирал	ГХБХБГ
Дүн			1.4416			





Эдэлбэр газартай амины орон сууцны зориулалтаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт


№	Байршил	Нэгж талбарын тоо	Талбайн хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Мөрөн 8-р баг	33	1.8	Эдэлбэр газартай амины орон сууц	2-р улирал	ГХБХБГ
Дүн			1.8			



2. Төрийн байгууллагад эзэмшүүлж, ашиглуулах газрын төлөвлөлт




№	Байршил	Талбайн хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ	Хариуцах эзэн
1	6-р баг Ус цаг уур орчны шинжилгээний төвийн баруун талд	0.0347	Албан хэрэгцээнд	2-р улиралд		ГХБХБГ
2	8-р баг Мэргэжлийн хяналтын газар	0.0369	Албан контор	2-р улиралд		ГХБХБГ
3	6-р баг НИК ШТС-ийн баруун талд	0.0897	Албан хэрэгцээнд	2-р улиралд		ГХБХБГ
Дүн		0.1613				





3. Үйлдвэрлэлийн зориулалтаар дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын төлөвлөлт

№	Сумын нэр	Байршил	Эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил	Талбайн хэмжээ /га/	Газрын зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Мөрөн	8-р баг	14-р байрны зүүн талд	0.0024	Граж	2-р улиралд	ГХБХБГ
2	Мөрөн	6-р баг	Магнай трейд ШТС-ийн хойно	0.0373	Дугуй засвар	3-р улиралд	ГХБХБГ
3	Мөрөн	1-р баг	Гандангын зүүн талд	0.3	Худалдаа үйлчилгээ	2-р улиралд	ГХБХБГ
4	Мөрөн	12-р баг	12-р багийн засмал замын хойно	0.4	Худалдаа үйлчилгээ	2-р улиралд	ГХБХБГ
5	Мөрөн	13-р баг	Зам ангийн хойно	0.16	Худалдаа үйлчилгээ	3-р улиралд	ГХБХБГ
6	Мөрөн	8-р баг	Хөвсгөл эрчим хүч ХХК-ийн авто зогсоолын баруун талд	0.035	Худалдаа үйлчилгээ	2-р улиралд	ГХБХБГ
7	Мөрөн	1-р баг	Ирээдүй сургуулийн урд талд	0.25	Худалдаа үйлчилгээ	3-р улиралд	ГХБХБГ
Дүн				1.1847			







3. Хууль бус газар эзэмшилтийн талаар авах арга хэмжээ

№	Сумын нэр	Байршил	Зөвшөөрөлгүй газрын хэмжээ /га/	Газрын Зориулалт	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1	Мөрөн	5-р баг Цагаан-Уул захын баруун талд	0.00547	Үйлчилгээ	Суурь үнэ, торгууль төлүүлж эзэмшүүлэх	2-р улирал	ГХБХБГ
2	Мөрөн	5-р баг Цагаан-Уул захын баруун талд	0.00243	Үйлчилгээ	Суурь үнэ, торгууль төлүүлж эзэмшүүлэх	2-р улирал	ГХБХБГ
3	Мөрөн	8-р баг 4-р байрны баруун талд	0.0038	Граж	Суурь үнэ, торгууль төлүүлж эзэмшүүлэх	2-р улирал	ГХБХБГ
4	Мөрөн	8-р баг 8-56	0.1231	Гэр бүлийн хэрэгцээ	Суурь үнэ, торгууль төлүүлж эзэмшүүлэх	2-р улирал	ГХБХБГ
Нийт дүн			0.1348				



